



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/255

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а" дахь заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны ээлжит XI хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хошой аварга малчин, аймгийн аварга малчин, аймгийн аварга саальчин, аймгийн залуу аварга малчин гэр бүл, үр тариа, төмс хүнсний ногоо тариалж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн аймгийн аварга тариаланч хамт олон, тариаланч, ногоочин, механикжуулагч, аймгийн тэргүүний үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн өргөмжлөлийн үнэ 4335000 /Дөрвөн сая гурван зуун гучин таван мянган/ төгрөгийг аймгийн Засаг дарга данснаас зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Нармандах)-д зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД